# НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ /НАОБТГ/

2022 оны 12 сарын 30

Улаанбаатар хот

| Төлөвлөгөөний дугаар | ХБТББ-т тусгагдсан зорилт үйл ажиллагаа | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ(сая төгрөг) | Суурь түвшин | Зорилтод түвшин, үр дүн (Хөрөнгийн хэмжээ эх үүсвэр ) | | | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв (Сая.төг) | Төсвийн Гүйцэтгэл (сая.төг ) | | |
| 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | | | | | | |
| 5.2 Агаар, орчны бохирдлыг бууруулж, байгальд ээлтэй, үр ашигтай хэрэглээ нэмэгдүүлэх замаар эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлнэ. | | | | | | | | | | | | |
| 5.2.1 | НХТЖҮЧ-6.2.1, НЗДҮАХ-5.2.1 | Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоож, түүнд мөрдөх журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавина. | 2022 | НАОБТГ | - | - | Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоож, түүнд мөрдөх журмыг шинэчлэн | Журмыг шинэчлэн баталж, хэрэгжилтэд хяналт тавина. | - | | “Агаарын чанарыг сайжруулах бүс, түүнд мөрдөх журам”-ыг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлэн 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/424-А/1353 дугаартай Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг даргын хамтарсан тушаал, захирамжийг батлуулсан. Налайх дүүргийн 1,2,3,4,5,6,7,8 дугаар хороодын гэр хорооллын | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | баталсан | | | | 7,691 айл өрхийг Агаарын чанарыг сайжруулах бүсэд хамруулан тус дүүргийн нутаг гэр хорооллын дэвсгэрт 33 хяналтын ажилтан иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэн хяналт тавин хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | |
| 5.2.2 | НХТЖҮЧ-6.2.1, НЗДҮАХ-5.2.1 | Сайжруулсан түлшний зүүн үйлдвэрийн үйл ажиллагааг жигдрүүлнэ. | 2022 | НАОБТГ | - | - | Үйлдвэрийн тоног төхөөрөмж угсрагдсан | Үйл ажиллагааг жигдрүүлсэн байна. | - | | Халаалтын улирал эхэлсэнтэй холбогдуулан зүүн бүсийн үйлдвэр нь одоогийн байдлаар нийт 5 шугамаар 24 цагт 695 тонн сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэж байгаа бөгөөд 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийг хүртэл 107,669 тонн сайжруулсан шахмал түлшийг гэр хорооллын айл өрхийн хэрэглээ болон нөөцлөлтөд зориулан үйлдвэрлэсэн. | 100% |
| 5.2.3 | НХТЖҮЧ-6.2.1, НЗДҮАХ-5.2.1 | Гэр хорооллын айл өрхийг стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр хангах, сайжруулсан | | НАОБТГ | - | 32,950.1 | 604,392 тн сайжруулсан түлш борлуулсан. | 607,695 тн түлш сайжруулсан түлш борлуулна. | 33,5 | 28,8 | Нийслэлийн 7 дүүргийн гэр хорооллын 203,683 айл өрхийг сайжруулсан шахмал түлшээр хангах ажлын хүрээнд 2022 онд сайжруулсан шахмал түлшний тээврийн 31 компанитай гэрээ байгуулан 650 | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | түлшийг түгээх, тээвэрлэх, борлуулах үйл ажиллагааг дэмжиж, хяналт тавина. | | | | | | | - | | борлуулалтын цэгт 568,722 тонн сайжруулсан шахмал түлшийг борлуулан ажиллаж байна. Сайжруулсан шахмал түлшний тээвэрлэлт болон урамшууллын зардалд 28,8 тэрбум, төгрөгийг 2022 онд олгон хяналт тавин ажилласан. | |
| 5.2.4 | НХТЖҮЧ-6.2.1, НЗДҮАХ-5.2.1 | Сайжруулсан түлшний 2 агуулах барих газрын асуудлыг шийдвэрлэнэ. | 2022 | НАОБТГ | - | - | 2020 онд сайжруулсан түлшний 5 агуулах баригдсан. | Шинээр 2 агуулах нэмж барих газрын асуудлыг шийдвэрлэсэн байна. | - | | Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороонд сайжруулсан түлшний агуулах барих боломжтой 9,500м2, 17,000м2 2 байршлын агуулахын газрын асуудлыг шийдвэрлэсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу агуулах худалдан авах ажлыг зохион байгуулахаар нээлттэй тендер зарлан сонгон шалгаруулалтыг хийж гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн. | 100% |
| 5.2.5 | НХТЖҮЧ-6.2.1, | Агаарын бохирдлыг бууруулах цогц | 2022 | НАОБТГ | Нийслэлийн төсөв | 600.0 | PM2.5 тоосонцрын | PM2.5 тоосонцрын | 600.0 | | 2022 оны хүйтний улирлын 11 дүгээр сарын Улаанбаатар хотын агаар | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | НЗДҮАХ-5.2.1 | арга хэмжээ авна. | | | | | агууламжийг 55 мкг/м3, PM10 тоосонцрын агууламж 115 мкг/м3 байна. | агууламжийг 50 мкг/м3, PM10 тоосонцрын агууламж 107 мкг/м3-д хүргэж, бууруулсан байна. | | | дахь агаар бохирдуулах бодисын дундаж агууламж;<br>PM2.5 тоосонцор 55 мкг/м3,<br>PM10 тоосонцор 97 мкг/м3 байна.<br>-Суурин харуулын өвлийн бэлтгэл ажил хангах, хэмжилтийн тасралтгүй ажиллагааг хангуулах хүрээнд суурин харуулын сэлбэг хэрэгсэл худалдан авах тендерт шалгарсан "Интерсайнс" ХХК-тай 2022 оны 12-р сарын 01-ны өдөр 29,551.0 мян.төг-н гэрээ байгуулан худалдан авахаар ажиллаж байна.<br>-Агаарын чанарын хяналтын суурин харуулын болон суурин эх үүсвэрийн хэмжилтийн багаж төхөөрөмжүүдэд тохиргоо хийх зориулалттай стандарт хий худалдан авалтын тендерт шалгарсан "Универсал инженеринг" ХХК-тай 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр НАОБТГ03/03 тоот 29,970 сая.төг-н гэрээ байгуулж, стандарт хий худалдан авах шатандаа явагдаж байна. | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | -Хаягдал утааны хэмжилтийн тоног төхөөрөмжийн баталгаажилтын сэлбэг хэрэгсэл худалдан авах тендерт шалгарсан “Интерсайнс” ХХК-тай 2022 оны 11 дүгээр сарын 04-ны өдөр НАОБТГ03/02 тоот 30сая.төг-н гэрээ байгуулж худалдан авах шатандаа явагдаж байна. | |
| 5.2.9 | НХТЖҮЧ-6.2.2, НЗДҮАХ-5.2.2 | Авто замын хөдөлгөөнд оролцож буй нийтийн болон ачаа тээврийн хэрэгслийн хаягдал утааны агууламжийг тодорхойлох шинжилгээт хяналт шалгалт хийж, стандартад нийцүүлэх арга хэмжээ авна. | 2022 | НМХГ | Нийслэлийн төсөв | - | 1,200 тээврийн хэрэгсэлд хаягдал утааны агууламжийг тодорхойлох хяналт шалгалт хийсэн. | 1,200 тээврийн хэрэгсэлд хаягдал утааны агууламжийг тодорхойлох хяналт шалгалт хийсэн байна. | - | | 2022 оны байдлаар авто замын хөдөлгөөнд оролцож буй нийтийн болон ачаа тээврийн хэрэгслийн хаягдал утааны агууламжийг тодорхойлох хэмжилтийг Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Авто тээврийн үндэсний төвтэй хамтран 50 автомашинд хэмжилт хийж ажилласан.<br><br>Үлдсэн хэмжилтийн ажил Автотээврийн Үндэсний төв ТӨҮГ, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Тээврийн Цагдаагийн алба зэрэг газруудтай хамтарч хийгддэг бөгөөд АТҮТ-д хэмжилтийн ажлууд их байгаа шалтгаанаар манай байгууллагатай | 70% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | хамтран ажиллах хугацаагаа 12-р сард болгох хүсэлт бидэнд ирүүлсний улмаас энэ ажил хойшлогдсон. | |
| 5.2.10 | НХТЖҮЧ-6.2.2, НЗДҮАХ-5.2.3 | Агаарын бохирдлын хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх хор уршиг, түүнийг бууруулах, угаарын хий, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэхийн тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар иргэн, хуулийн этгээдэд сургалт зохион байгуулж, зөвлөмж, сэрэмжлүүлэг хүргүүлнэ. | 2022 | НАОБТГ | Нийслэлийн төсөв | - | 6 дүүрэгт тус бүрт 1 сургалт зохион байгуулж, 10 постер, 4 шторк бэлтгэн иргэдэд мэдээлэх ажлыг зохон байгуулсан. | Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр олон нийтийн оролцоог хамарсан 3 арга хэмжээг зохион байгуулж, 15 постер, 5 шторк бэлтгэн иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулсан байна. | - | | Тайлант хугацаанд 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах сургалтыг 5 удаа, "Агаар, орчны бохирдлыг бууруулах ногоон технологи-2022" үзэсгэлэн 1 удаа, видео шторк 6, зурагт хуудас /постер/, баннерыг 20 тус тус байгууллагын цахим хуудас, вэбсайт болон хамтран ажилладаг вэбсайт, Нийслэлийн мэдээ, телевизүүдэд байршуулан иргэд олон нийтэд тогтмол хүргэн ажилласан. | 100% |
| 5.2.14 | НХТЖҮЧ-6.2.2, НЗДҮАХ-5.2.2 | Нийслэлийн агаарын чанарын хяналтын чадавхыг сайжруулж, | 2022 | НАОБТГ | Гадаадын тусламж | 1,000.0 | Автомат суурин станц 6 | 1 автомат суурин станцад оруулна. | 1,000.0 | | БЗД-ийн 9 дүгээр хороо СЭМҮТөвийн орчим, Налайх дүүргийн 7 дугаар хороонд Франц улсад үйлдвэрлэгдсэн ENVIRONMENTAL-SA | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | суурин автомат станцын тоог нэмэгдүүлж тасралтгүй ажиллагааг хангана. | | | | | | | | 1,400.0 | маркийн орчны агаарын чанарыг 13 үзүүлэлтээр тодорхойлох 2 суурин харуулыг суурилуулснаар Улаанбаатар хотын агаарын чанар тодорхойлох хяналтын сүлжээний хүчин чадал нэмэгдэж, Суурин харуул суурилагдаагүй дүүрэгт оршин сууж байгаа иргэдийн агаарын бохирдлын өртөлтийн хэмжээг тодорхойлох боломж бүрдэнэ. | |
| 5.2.15 | НХТЖҮЧ-6.2.2, НЗДҮАХ-5.2.2 | Агаар бохирдуулж байгаа эх үүсвэрийн тооллого явуулж, бүртгэл, мэдээллийн сан шинэчлэн бүрдүүлнэ. | 2022 | НАОБТГ | Нийслэлийн төсөв | - | Жил бүр тооллого явуулж, бүртгэл мэдээллийн санг шинэчилдэг. | Тооллого явуулж, бохирдуулагч эх үүсвэрийн мэдээллийн санг шинэчилсэн байна. | - | | Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогыг жил бүр хийдэг бөгөөд 2021-2022 оны агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэл хийх ажлыг батлагдсан маягтын дагуу бөглөж, www.envpol.mne.gov.mn цахим системд бүртгэлжүүлж, 3-15квт хүчин чадалтай ахуйн хэрэглээний **163,742** зуух, 16-100 кВт хүчин чадалтай **2,469** зуух, 100 кВт-аас дээш хүчин чадалтай **410** усан халаалтын зуух, Дулааны цахилгаан 6 станцын 4200 кВт-аас дээш хүчин чадалтай **41** | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | зуух тус тус тоологдсон. Мөн хөдөлгөөнт эх үүсвэр буюу 661,348 авто тээврийн хэрэгсэл тоологдож мэдээллийн сан үүсгэсэн. | |
| Хамтрангаар хэрэгжүүлэх | | | | | | | | | | | | |
| 5.2.6 | НХТЖҮЧ-6.2.1, НЗДҮАХ-5.2.1 | Шахмал түлшнээс дээж авч бүтээгдэхүүний чанар стандартын байдалд хяналт шалгалт хийнэ. | 2022 | НМХГ | Нийслэлийн төсөв | - | Таван толгой түлш ХХК-ийн үйлдвэрлэсэн шахмал түлш стандартын шаардага хангаж буй эсэх талаар улсын /ахлах/ байцаагчийн 43 дүгнэлт гаргасан. | 20 удаа дээж авч шинжилгээнд хамруулан, хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргасан байна. | - | | Үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтээр 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд нийт **70** дээжид хаягдал утааны хэмжилт хийж дүнг боловсруулж Монгол Улсын MNS5216:2016 стандартыг баримтлан заасан үзүүлэлттэй тус тус харьцуулан холбогдох албан байгууллага ААНБ-д хүргүүлсэн. | 100% |
| 5.2.7 | НХТЖҮЧ-6.2.1, НЗДҮАХ-5.2.1 | Уурын болон 100 кВт-аас дээш хүчин чадалтай усан халаалтын зуух ашиглагч, дулаан, | 2022 | НМХГ | Нийслэлийн төсөв | - | 160 аж ахуйн нэгж, байгууллагад хяналт | 160 аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт | - | | Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2022 оны А/74, А/77, А/220 тоот тушаалаар эрчим хүчний тусгай зөвшөөрөлтэй 20 аж ахуйн нэгж, байгууллагын 182 усан | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | цахилгаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийж, үйл ажиллагааг сайжруулна. | | | | шалгалт хийсэн. | хийсэн байна. | | | халаалтын зуух, технологийн зориулалтын дагуу уур үйлдвэрлэн үйл ажиллагаа явуулж байгаа 68 аж ахуйн нэгж, байгууллагуудад 88 зууханд 3 удаагийн үе шаттайгаар утааны хийн шүүлтүүрийн хэвийн ажиллагаа, нүүрс, үнсний агуулах савны битүүмжлэл, өвөлжилтийн бэлтгэл хангасан эсэхэд хяналт шалгалт хийж ажилласан. Нийт тусгай зөвшөөрөлтэй 68 байршлын 166 зуухнаас Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 16 байршлын 39 зууханд утаа шүүгчтэй байгаа бөгөөд ажиллаж байгаа 10 байршлын 18 зуух, ажиллахгүй 6 байршлын 21 зуух байна. Мөн тус аж ахуйн нэгж, байгууллагын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлын талаар Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5.2.11 | НЗДҮАХ-5.2.4 | Гэр хорооллын айл өрхийг халаалтаа дэвшилтэт технологи бүхий шөнийн дулаан хуримтлуурт цахилгаан халаагуураар шийдэх төслийг үргэлжлүүлнэ. | 2022 | УБЦ НС төслийн нэгж, НЗДТГ-ын ЭЗХТХХТХ | Гадаадын зээл | 500.0 | 240 өрх халаалтаа дэвшилтэт технологиор шийдвэрлэсэн. | 100 өрхийг төсөлд хамруулсан. | | | 2021 онд **282** айл өрхөд шөнийн дулаан хуримтлуурт цахилгаан халаагуурыг суурилуулсан. Тус төсөл арга хэмжээнд Сонгинохайрхан дүүргээс -**147** өрх, Хан-Уул дүүрэг-**9** өрх, Баянзүрх дүүрэг -**18** өрх, Баянгол дүүрэг-**15** өрх, Чингэлтэй дүүрэг -**55** өрх, Сүхбаатар дүүргээс -**38** өрх тус тус хамрагдсан. 2022 онд "Хуримтлуурт халаагуур"-ын төсөл хөтөлбөр дууссантай холбоотойгоор 2022 онд зөвхөн "Дулаалга аян"-ыг дангаар хэрэгжүүлж, 94 айл өрхийн байшин сууцыг дулаалсан. | 70% |
| 5.2.12 | НЗДҮАХ-5.2.4 | Төвлөрсөн дулаанд холбогдох боломжгүй байршил дахь 1 сургууль эсвэл цэцэрлэгт газрын гүний дулааны систем суурилуулна. | 2022 | УБЦ НС төслийн нэгж, НЗДТГ-ын ЭЗХТХХТХ | Гадаадын зээл | 1,600.0 | 1 сургуулийг газрын гүний дулааны системд холбосон | 1 сургууль эсвэл цэцэрлэгийг газрын гүний дулааны системд холбосон байна. | 1,600.0 | 819.0 | Нийслэлийн төрийн өмчийн халаалтын зуухыг буулгаж, төвлөрсөн дулаан хангамжид холбох ажлын хүрээнд Чингэлтэй дүүргийн 15-р хороонд байрлах 83-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилга Хорооны 1 барилга, Зэвсэгт хүчний цэргийн ангийн барилга 1 нийт 3 барилгын халаалтын зуухыг буулгаж төвлөрсөн дулаан хангамжид холбосон. | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5.2.13 | НЗДҮАХ-5.2.4 | Гэр хорооллын айл өрхийн орон байрны дулаан алдагдлыг бууруулахад чиглэсэн "Дулаалга аян" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 2022 | УБЦ НС төслийн нэгж, НЗДТГ-ын ЭЗХТХХТХ | Гадаадын зээл | 500.0 | 240 өрхийн байшин сууцыг дулаалсан. | 100 өрхийн байшин сууцыг дулаалсан байна. | | | "Шөнийн дулаан хуримтлуурт цахилгаан халаагуур"-аар айл өрхийн халаалтыг шийдвэрлэх арга хэмжээтэй уялдуулж, "Халаалт, дулаалгын цогц шийдэл" хөтөлбөр болгон хэрэгжүүлсэн бол "Хуримтлуурт халаагуур"-ын төсөл хөтөлбөр дуусcантай холбоотойгоор 2022 онд зөвхөн "Дулаалга аян"-ыг дангаар хэрэгжүүлж, 94 айл өрхийн байшин сууцыг дулаалсан | 90% |

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА О.АЛТАНГЭРЭЛ

ТАЙЛАГНАСАН:
ЗСХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН Б.НУРБАХЫТ